



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/215

Мөрөн сум

Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг
хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 60.1.17, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, 14.3, Аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймаг дахь төрийн Аудитын байгууллагаас аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 1 дүгээр, төсвийн гүйцэтгэлийн тайланд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2 дугаар, "Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн" гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог), Санхүүгийн хяналт аудитын алба (Г.Мөнхтулга), сумдын Засаг дарга нар, бүх шатны төсөв захирагч, санхүүгийн ажилтнуудад үүрэг болгосугай.

3. Дээрх төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн зэрэгцээ сум, байгууллагуудын 2021 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд Төрийн аудитын байгууллагаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх, төлөвлөгөөг тус бүрдээ гаргаж хэрэгжүүлэн, заасан хугацаанд тайлагнаж, өөрийн төсөвт хамаарах хугацаа хэтэрсэн өр, авлагыг бууруулж ажиллахыг бүх шатны төсөв захирагч нарт даалгасугай.

4. 2021 оны санхүүгийн тайланд төрийн Аудитын байгууллагаас "хязгаарлалттай" санал дүгнэлт авсан Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын төсвийн шууд захирагч, "Түнэл илч" ХХК, Шинэ мөрөн худалдаа үйлчилгээний төв" ХХК-ийн төсөв захирагч нарт ажил сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, зөрчил дутагдал давтан гаргахгүй байхыг үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн засаг даргын 2022 оны 06..
дугаар сарын 24 ний өдрийн 1215 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ ХЭРЭГЖИХ
ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Зөвлөмжийн агуулга | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжилтийг хангах байгууллага | Хэрэгжилтэнд хяналт тавих байгууллага |
|---|--|---|---|---------------------------------------|
| 1 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль жуурманд нийцүүлэн шинэчлэн боловсруулах, мөрдүүлэх | -НББ-ын бодлогын баримт бичгийн шаардлагатай хэсгийг холбогдох хууль жуурманд нийцүүлэн өөрчлөх. | Санхүү төрийн сангийн хэлтэс | Санхүү төрийн сангийн хэлтэс |
| 2 | Сумын санхүүгийн албаны дарга, мэргэжилтэн, нягтлан бодогчдыг "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-ийн 3 дугаар зүйлийн 3.1.3, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалын хавсралт "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шалгуур журам"-ын 2.1.1, 2.1.5 дахь заалтад нийцүүлэн томилох | - Журамд заасан шалгуур зхангасан хүнийг томило -Зөвшилцөх нэр бүхий албан хаагчтай заавал зөвшилцөх - Шаардлага хангах хүний нөөц бүрдүүлэхэд анхаарах | -Бүх шатны төсөв захирагч нарт | Санхүү төрийн сангийн хэлтэс |
| 3 | Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсөв захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" заалтыг хэрэгжүүлж төсвийн шууд захирагч, санхүүгийн албыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллаж байх. | -Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсөв захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" заалтыг хэрэгжүүлж ажиллана. | -Бүх шатны төсөв захирагч нарт -Санхүү төрийн сангийн хэлтэс | Санхүү төрийн сангийн хэлтэс |
| 4 | Авлага өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж санхүүгийн тайланд тусгах, Орон сууцны түрээсийн гэрээ байгуулаагүй айл өрхүүдтэй түрээсийн гэрээг байгуулж, хуримтлагдсан авлагыг бууруулах чиглэлээр бодитой арга хэмжээ авах. | -Төлбөрийн дутуу тооцоотой иргэдтэй тулгалт хийх -Мэдэгдэл хүргүүлэх -Оршин суугчидтай хийх гэрээнд өөрчлөлт оруулах талаар ИТХ-р баталсан ажлын хэсгийнхэн МУХБ-тай | -Орон нутгийн өмчийн газар | Орон нутгийн өмчийн газар |

| | | | | |
|---|--|--|--|------------------------------|
| | | биечлэн уулзах, хамтран ажиллах | | |
| 5 | Өрийн удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.11 дэх заалттай нийцүүлэн, орон нутгийн төсөв болон түрээслэгчдэд дарамт учруулахгүйгээр гэрээнд өөрчлөлт оруулах. | -Гэрээнд өөрчлөлт оруулах талаар саналыг МУХБ-нд хүргүүлсэн хариуг эцсийн шатанд шийдвэрлүүлж иргэдтэй гэрээг байгуулж,хуримтлагдсан өр авлагыг төлүүлж цэгцлэх | -Орон нутгийн өмчийн газар | Орон нутгийн өмчийн газар |
| 6 | Байгууллагуудын нэр, улсын бүртгэлийн гэрчилгээн дэх нэрийг холбогдох хууль журамд нийцүүлэн өөрчлөх, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалтыг хэрэгжүүлж байгууллагуудын хүрээнд зохион байгуулж ажиллах. | -Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлтийг төрийн Аудитын байгууллагад хугацаанд нь гаргаж хүргүүлэх. | -Санхүү төрийн сангийн -Орон нутгийн өмчийн газар - Бүх шатны төсөв захирагчид | Орон нутгийн өмчийн газар |
| 7 | Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангаар илэрсэн алдаа, зөрчлийн биелэлтэнд анхаарал хандуулж, хэрэгжилтийг бодитой тооцон, биелэлтийг Төрийн аудитын газарт ирүүлэх. | -Ирсэн акт, албан шаардлага, зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гаргах -Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг төрийн Аудитын байгууллагад хугацаанд нь гаргаж хүргүүлэх. | -Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид | Санхүү төрийн сангийн хэлтэс |
| 8 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах | -Шилэн дансны мэдээллийг цаг хугацаандаа бүрэн оруулах, оруулж буй эсэхийг хянах -оруулсан мэдээлэл үнэн зөв байх, үнэн зөв эсэхийг хянах -Шилэн дансны тайланг илгээх, илгээсэн эсэхийг хянах -хэрэгжилтийг үнэлж зөвлөмж гаргах | - Бүх шатны төсөв захирагчид -санхүү хяналт аудитын газар | санхүү хяналт аудитын газар |

Аймгийн засаг даргын 2022 оны 06...
дугаар сарын 24... ний өдрийн 11/215 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2021 ОНЫ
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ
ХЭРЭГЖИХ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Зөвлөмжийн агуулга | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжилтийг хангах байгууллага | Хэрэгжилтэнд хяналт тавих байгууллага |
|---|---|--|--|--|
| 1 | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсвийн гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг бүрэн хангаж ажиллах | -Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж ажиллах. | - Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс -Орон нутгийн өмчийн газар | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс |
| 2 | Төсвийн төлөвлөлтийн суурь судалгааны чанарыг сайжруулж төсвийг оновчтой зөв төлөвлөж хуваарилж байх төлөвлөсөн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах | -Орон нутгийн төсвийн төслийг холбогдох маягт, аргачлалын дагуу бэлтгэх, хянуулах, батлуулах | -Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид | Санхүү төрийн сангийн хэлтэс |
| 3 | Төсвийн орлогыг орлогын нэр төрлөөр жигд ханган биелүүлж, төсвийн захирагчдын хуулиар хүлээсэн үүргийг бүрэн хангуулж ажиллах | -Татвар төлөгчдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах -Орлогын сар бүрийн бүрдэлтэд хяналт тавьж удирдлагуудыг мэдээллээр хангах | -Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид | Санхүү төрийн сангийн хэлтэс |
| 4 | Техник хяналтын зардлын төсөв батлан хяналтыг сайжруулах | -Төсөвт батлах боломжтой эсэхийг судлах | -Орон нутгийн өмчийн газар | Орон нутгийн өмчийн газар |
| 5 | Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх санг орон нутгын төсөвт төлөвлөж гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах. | -Ажлын хэсгийг шинэчлэн батлах -Ажлын хэсэг явцын хяналт хийх -Төсөвт батлах боломжтой эсэхийг судлах | - Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс |
| 6 | Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах | -Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангах | -Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид | Санхүү төрийн сангийн хэлтэс |
| 7 | Орон нутгийн орлогын төлөвлөгөөг тооцоо, судалгааг үндэслэн боловсруулж батлуулан, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах. | -Орон нутгийн орлогын төсвийн төслийг холбогдох маягт, аргачлалын дагуу бэлтгэх, хянуулах, батлуулах | -Санхүү төрийн сангийн хэлтэс -Бүх шатны төсөв захирагчид | Санхүү төрийн сангийн хэлтэс |

Аймгийн засаг даргын 2022 оны 06...
дугаар сарын 24 ний өдрийн А/25 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт



“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ,
ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮН”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ
ХЭРЭГЖИХ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Зөвлөмжийн агуулга | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжилтийг хангах байгууллага | Хэрэгжилтэнд хяналт тавих байгууллага |
|---|--|--|--|--|
| 1 | Иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн, Төсвийн тухай хууль болон холбогдох журамд заасан чиг үүрэгт нийцсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэлэлцэн батлах | -иргэдийн саналын цахимаар авч тоолж эрэмбэлэх - ОНХС-ийн УМС-д иргэдийн саналыг ангилан зөв оруулах -Ажлын хэсэг байгуулсан захирамжийг оруулах | Сумдын ИТХ-ын дарга нар | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс |
| 2 | Сумдын ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэлд хийх хяналтыг чанартай хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллах | -Сар бүр сумдын гүйцэтгэлийн мэдээг нэгтгэх | Сумдын ИТХ-ын дарга нар | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс |
| 3 | ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлт гаргаж байх | -Ашиглагч байгууллага тооцоо судалгааг ирүүлэх -Судалгааг үндэслэж холбогдох дүгнэлт гаргах | -Холбогдох төсөв захирагч нарт -Орон нутгийн өмчийн газар | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс Санхүү, төрийн сангийн хэлтэс Орон нутгийн өмчийн газар |
| 4 | ОНХС-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв, иж бүрэн мэдээлэх. | -УМС төлөвлөлт, гүйцэтгэлийн мэдээллийг хуулийн хугацаанд оруулсан байх | Сумдын Засаг дарга нар | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс |
| 5 | ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалт, хадгалалт хамгаалалт үр дүнг сайжруулж, ашиглалтгүй байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж ажиллах | -Ашиглалтгүй байгаа өмч хөрөнгийн судалгааг гаргах -Судалгааг үндэслэн холбогдох арга хэмжээг авч ажиллах | -Холбогдох төсөв захирагч нарт -Орон нутгийн өмчийн газар | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс Санхүү, төрийн сангийн хэлтэс Орон нутгийн өмчийн газар |



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/214

Мөрөн сум

Урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 60.1.17, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 40 дүгээр зүйлийн 40.4.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн чанар байдал, иж бүрдэл, тайлагнасан хугацаа, илэрсэн алдаа зөрчил, өр, авлагын өсөлт, бууралт, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиласан байдал зэргийг харгалзан санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан сумын Засаг дарга нарт нэг удаа олгох мөнгөн урамшууллын хувь, хэмжээг 1 дүгээр, аймгийн төрийн сантай шууд харьцдаг төсвийн шууд захирагч нарт нэг удаа олгох мөнгөн урамшууллын хувь хэмжээг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон байгууллагын санхүүгийн тайлангийн чанар байдал, тайлагнасан хугацаа, илэрсэн алдаа зөрчил, өр, авлагын өсөлт, бууралт, барагдуулалт, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиласан байдал, төрийн Аудитын байгууллагаас эдгээр асуудалтай холбоотой хариуцлага тооцох санал ирүүлсэн нөхцөл байдлыг харгалзан тухайн байгууллагын цалингийн санд багтааж төсвийн шууд захирагч нарт нэг удаа мөнгөн урамшуулал олгох болон хариуцлага тооцож ажиллахыг сумын Засаг дарга нарт, санхүүгийн ажилтнуудад нэг удаа мөнгөн урамшуулал олгох болон хариуцлага тооцож ажиллахыг төсвийн шууд захирагч нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт авч ажиллахад голлох үүргийг гүйцэтгэж ажилласан аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, алба хаагч нарт мөнгөн урамшуулал олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын төсвийн шууд захирагчид зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтийн дарга (Г.Базар), Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Мөнгөн-Эрдэнэ) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 24 ний өдрийн 124 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



УРАМШУУЛАЛ ОЛГОХ СУМЫН ЖАГСААЛТ

| № | Сумын нэр | Хугацаа | Аудитаар илэрсэн зөрчлөөр | Өр, авлагаар | Тайлангийн чанар, иж бүрдэл | Урамшуулал тооцох хувь |
|----|----------------|---------|---------------------------|--------------|-----------------------------|------------------------|
| 1 | Арбулаг | 60 | 70 | 80 | 70 | 70 |
| 2 | Баянзүрх | 70 | 70 | 80 | 80 | 75 |
| 3 | Бүрэнтогтох | 100 | 80 | 80 | 80 | 85 |
| 4 | Галт | 60 | 80 | 80 | 80 | 75 |
| 5 | Жаргалант | 90 | 70 | 70 | 70 | 75 |
| 6 | Их-Уул | 100 | 80 | 70 | 70 | 80 |
| 7 | Рашаант | 80 | 80 | 80 | 80 | 80 |
| 8 | Ренчинлхүмбэ | 100 | 80 | 80 | 80 | 85 |
| 9 | Тариалан | 100 | 70 | 70 | 80 | 80 |
| 10 | Тосонцэнгэл | 100 | 80 | 60 | 80 | 80 |
| 11 | Төмөрбулаг | 100 | 70 | 80 | 70 | 80 |
| 12 | Түнэл | 100 | 60 | 80 | 60 | 75 |
| 13 | Улаан-Уул | 100 | 80 | 80 | 80 | 85 |
| 14 | Ханх | 60 | 60 | 80 | 60 | 65 |
| 15 | Цагаан-Уул | 100 | 80 | 80 | 80 | 85 |
| 16 | Цагаан-Үүр | 80 | 75 | 75 | 70 | 75 |
| 17 | Цэцэрлэг | 100 | 80 | 80 | 80 | 85 |
| 18 | Чандмань-Өндөр | 70 | 80 | 80 | 70 | 75 |
| 19 | Шинэ-Идэр | 100 | 80 | 80 | 80 | 85 |
| 20 | Хатгал | 100 | 70 | 80 | 70 | 80 |
| 21 | Мөрөн | 100 | 90 | 70 | 80 | 85 |
| 22 | Эрдэнэбулган | 60 | 80 | 70 | 70 | 70 |
| 23 | Цагааннуур | 100 | 80 | 80 | 80 | 85 |

Аймгийн Засаг даргын 2022 оны 06...
дугаар сарын 24 ний өдрийн 144 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



УРАМШУУЛАЛ ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

| № | Байгууллагын нэр | Хугацаа | Аудитаар илэрсэн зөрчлөөр | Өр, авлагаар | Тайлангийн чанар, иж бүрдэл | Урамшуулал тооцох хувь |
|----|--|---------|---------------------------|--------------|-----------------------------|------------------------|
| 1 | Ахмад настны асрамж үйлчилгээний газар | 100 | 90 | 100 | 90 | 95 |
| 2 | Байгаль орчин, аялал жуулчлалын газар | 100 | 80 | 100 | 80 | 90 |
| 3 | Биеийн тамир, спортын хороо | 100 | 70 | 100 | 70 | 85 |
| 4 | Засаг даргын тамгын газар | 100 | 100 | 100 | 100 | 100 |
| 5 | Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 100 | 90 | 100 | 90 | 95 |
| 6 | Нийтийн номын сан | 100 | 90 | 100 | 90 | 95 |
| 7 | Орон нутгийг судлах музей | 100 | 70 | 100 | 90 | 90 |
| 8 | Орон нутгийн өмчийн газар | 100 | 100 | 100 | 80 | 95 |
| 9 | Санхүүгийн хяналт аудитын алба | 100 | 70 | 100 | 70 | 85 |
| 10 | Халамжийн сан | 100 | 80 | 100 | 80 | 90 |
| 11 | Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс | 100 | 80 | 100 | 80 | 90 |
| 12 | Хөгжимт драмын театр | 100 | 80 | 100 | 80 | 90 |
| 13 | Хөвсгөл аймгийн Соёл урлагийн газар | 100 | 60 | 100 | 80 | 85 |



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/197

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төөлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн албан хаагчдын Монгол хэл, бичгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх арга хэмжээнд 1,1000,000 (Арван нэгэн сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 1,1000,000 (Арван нэгэн сая) төгрөгийг Засаг дарга дансны "Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тусгагдсан зарим арга хэмжээг санхүүжүүлэх" зардлаас гаргаж зарцуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Ч.Ганбатаар)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

81518-210801



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 5/29

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 601.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 14 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийг амжилттай хэрэгжүүлж байгаа Ерөнхий боловсролын “Дэлгэрмөрөн цогцолбор” сургууль, Ерөнхий боловсролын “Авьяас” сургууль, Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуульд тус бүр 500.000 (таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг олгосугай.

2. Дээрх зардлын 1.500.000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг Засаг дарга дансны “Иргэд байгууллагаас ирсэн санал, хүсэлтийг шийдвэрлэх зардал”-аас гаргаж зарцуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ч.Ганбатаар)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН